ҮАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# МАЛ ХАМГААЛАХ САНГИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Аудитын код: САГ/2018/13/СТА-3ГТС**


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням
Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamya@audit.gov.mn

Ахлах аудитор Цолмон
Утас: 261740 Цахим хаяг:tsolmon@audit.gov.mn

Латана аудит ХХК-ийн захирал Л.Нансалмаа
Утас: 9917-3084 Цахим хаяг: latana.audit@gmail.com

Чанарын хяналтын мэргэжилтэн Д.Отгонжаргал
Утас: 9909-5096 Цахим хаяг: latana.audit@gmail.com

Аудитор Д.Амарзаяа
Утас: 7741-0004 Цахим хаяг: latana.audit@gmail.com


01 | ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Улаанбаатар хот

## Агуулга


1 Аудитын гэрчилгээ ........ 1
2 Аудитын тайлан ........ 3
2.1 Оршил ........ 3
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........ 3
2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........ 4
2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ........ 4
2.5 Дотоод хяналт ........ 5
2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ........ 5
2.7 Шилэн дансны мэдээлэл ........ 5
2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар ........ 6
2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл ........ 5
2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал ........ 6
2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд ........ 6
2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл ........ 7
2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 7
2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар: ........ 7
2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ........ 7
3 Менежментийн захидал ........ 8
3.1 Мөнгөн хөрөнгийн талаар ........ 9
3.2 Өмнөх оны үр дүнгийн талаар ........ 10
3.3 Тайлант оны үр дүнгийн талаар ........ 11
4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ........ 11-12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 13-14
4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 15
4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 16-17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 18
4.6 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан нт-2 ........ 19


01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.23 № 06/828
танай ______________-ны № ______________-т

МАЛ ХАМГААЛАХ САНГИЙН
ЗАХИРАЛ Т.ЦЭДЭНДАМБАА
ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал хамгаалах сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Мал хамгаалах сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мал хамгаалах сангийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0323SAG48.Docx

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

071546

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

УХА0122

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0323SAG48.Docx

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

# 2 АУДИТЫН ТАЙЛАН

## 2.1 Оршил

Мал хамгаалах сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Мал хамгаалах сангийн захирал Т.Цэдэндамбаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, зардлыг төсөвлөх, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн тайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

## 2.2 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал хамгаалах сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Мал хамгаалах сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 02 дугаар сарын 05 -наас 2018 оны 2 дугаар сарын 25 –ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Латана аудит ХХК-ийн Б. Эрдэнэбилэг, аудитор Д.Амарзаяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Мал хамгаалах сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газрын 2018 оны 2 дугаар сарын 03 -ны өдрийн албан бичгээр Латана аудит ХХК-д ирүүлсэн байна.

01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Мал хамгаалах сан нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Мал хамгаалах сан нь Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, аудитын тухай хууль, Нийгэмийн даатгалын тухай хууль, Татварын ерөнхий хуулиуд болон УСНББОУС, Сангийн сайдын баталсан холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуулинд өөрчлөлт ороогүй байна.

Мал хамгаалах сан нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Мал аж ахуйн салбарт хэрэгжиж буй Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих ,Монгол мал зэрэг хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилтот арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилгоор мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд техник технологийн болон эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх , зээлийн ашиглалтанд хяналт тавих ,зээлийг эргэн төвлөрүүлэх.

Засгийн газрын 2013 оны 11-р сарын 30-ны өдрийн 394 дүгээр тогтоолоор “Хонины ноос, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин,мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс , шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу урамшуулал олгох

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16.1 “*Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна”* гэж заасны дагуу Мал хамгаалах сангийн захирал Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Мал хамгаалах сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

## 2.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд УСНББОУС ,Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд болон Сангийн сайдын баталсан холбогдох заавар, журмыг мөрдлөгө болгон ашиглав.

Аудитаар мал хамгаалах сангийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжуулла. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын 3 чиглэлд 24 сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ХХААСайдын 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Мал хамгаалах сан нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагаандаа санхүүгийн “Acolous” програмыг ашиглаж байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Мал хамгаалах сангийн Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд ”бага“ буюу мэдээллийн технологийн аудитын мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул санхүүгийн програмын үйлдлийн горимд нарийн хяналттайгаар аудитыг хийж гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Аудитаар Мал хамгаалах сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

## 2.5 ДОТООД ХЯНАЛТ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Мал хамгалах сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

## 2.6 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн шууд захирагчийн 2017 онд ноос арьс ширний урамшуулал, эргэн төлөгдөх зээлд 77, 567.1 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Төсвийн зардлын ноос арьс ширний урамшууланд 35,638.6 сая төгрөг, урсгал зардалд 307,8 сая төгрөг зарцуулжээ.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд 100,75 хувийн гүйцэтгэлтэй байна.

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу төрийн сан дахь харилцах дансаар, Монгол банкаар, дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Мал хамгаалах сан төсвийн захирагчид 2017 онд улсын төвлөрсөн төсвөөс урсгал зардалд 35,658.1 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, нийт олгосон санхүүжилтээс 35,926.7 сая төгрөг, нэмэлт санхүүжилтээр Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 135.3 сая төгрөгийн санхүүжилт авч, олгосон санхүүжилтээс 177.8 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.7 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Тус төсвийн захирагч нь shilendans.gov.mn сайтад Шилэн дансны тухай хуулийн 5.6.7 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор өөрийн веббсайтад шилэн данс цэсийг байршуулж 3 төрлийн дараах мэдээллийг оруулсан байна.

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв,гүйцэтгэл ,хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт,
- Тухайн тайлант хугацааны төсөвт орсон нэмэлт,өөрчлөлт
- цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ

ХХААХҮЯ-ны хяналт-шинжилгээ, үнэлгээ ,дотоод аудитын газар нь харьяа байгууллага төсөл хөтөлбөрөөс шилэн дансны тайланг улиралаар авч сайтад оруулсан мэдээлэлтэй тулган Сангийн яам болон Үндэсний аудитын газарт хүргүүлсэн байна.

## 2.8 ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД ТООЦСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 3 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 24 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

## 2.9 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

2003 оноос хойш иргэн, аж ахуйн нэгжид олгосон зээлээс хугацаа хэтэрсэн 3,450,0 сая төгрөгийн зээлийн асуудлыг шүүхэд шилжүүлсэн, 12,252.2 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, зээлийн эргэн төлөлт 18.3 хувьтай байна. Зээлийн эргэн төлөлтөөс нэр, хаяг тодорхойгүй 16.9 сая төгрөгийг бусад өглөгт бүртгэсэн байна.

## 2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

ХХААЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А/127 дугаар тушаалаар 2011 онд “Гацуурт” ХХК-тай байгуулсан зээлийн гэрээний хэрэгжилтийг шалгах тооцоо нийлэх ажлын хэсгийг байгуулж ажилласан байна. Ажлын хэсэг нь ялгаж бэлтгэсэн 200 толгой үхрийг Сэлэнгэ аймгийн ХААГ-т шилжүүлж өгөхөөр “Гацуурт ХХК-тай тохирсон байна. Гацуурт ХХК-ийн зээлийн өрийн үлдэгдэл 3.0 тэрбум төгрөг, 2017 оны 10 дугаар сард ажлын хэсэг байгуулагдаж 140 толгой үхрийг нэг бүрийг 5 сая төгрөгөөр тооцож нийт 700.0 сая төгрөгийн өр барагдсан байна. Мөн “АТААСҮ” ХХК-д олгосон 450.0 сая төгрөгийн зээлийн өр шийдвэрлэгдээгүй байна.
Төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх бараа үйлчилгээний зардал 7%,үндсэн цалин 5,4%,унаа болон бусад нөхөн олговор 27,3%-иар хэтэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.” *төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”* гэж заасныг зөрчсөн байна.
Эдгээр асуудлыг дараагийн шалгалтаар үзэх шаардлагатай гэж үзэв.

Мал хамгаалах сангийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар дээрх асуудлуудыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.11 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Мал хамгаалах сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 311. 0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд менежментийн захидлаар зөвлөмж өгч санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

## 2.12 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Мал хамгаалах сангийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 2 асуудлаар зөвлөмж өгөгдсөн байна. Өгөгдсөн зөвлөмжийг дагаж мөрдөөгүй байсан нь 2017 оны санхүүгийн тайланд илэрч байсан. Үүнийг залруулж аудитлагдсан тайлан бэлтгэсэн.

## 2.13 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Мал хамгаалах сангийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 58,124.1 сая төгрөг бөгөөд 1 хувиар буюу 58.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

## 2.14 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Мал хамгаалах сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Иймд дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Мал хамгаалах сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн "Зөрчилгүй " санал дүгнэлт гаргалаа.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ ньМал хамгаалах сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дараалаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| **3.1 Мөнгөн хөрөнгийн талаар** | **Тэргүүлэх ач холбогдол №1** |
|---|---|

**ҮАГ-ын ажиглалт**

Мөнгөн гйүлгээний тайланд цэвэр мөнгөн гүйлгээ мөнгөн хөрөнгийн эхний эцсийн үлдэгдлийг хасаж тодорхойлсон дүнгээс 52,1 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан.

**ҮАГ-ын зөвлөмж**

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу санхүүгийн тайланг залруулах

**Хэрэгжих хугацаа :**

2018 оны 06 дугаар сарын 25 –ны дотор санхүүгийн програм хангамжийн тохируулгыг хийх

**Эрсдэлүүд**

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу 3 дугаар хавсралтын 6.7 “ Тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс эцсийн үлдэгдэлийг хасаж тодорхйолсон мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт нь мөнгөн гүйлгээний тайланд тодорхойлогдсон “нийт цэвэр мөнгөн гйүлгээ “гэсэн дүнтэй тэнцүү байна” заалтыг зөрчсөн.

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг зөвшөөрсөн болно..

2018 оны 3 дугаар сарын 25

| | |
|---|---|
| 01 | ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА<br>ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ |

| 3.2 ӨМНӨХ ОНЫ ҮР ДҮНГИЙН ТАЛААР | Тэргүүлэх ач холбогдол №2 |
|---|---|

**<u>ҮАГ-ын ажиглалт</u>**

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх оны үйл ажиллагааны нийт үр дүнг санхүүгийн байдлын тайлангаархи эхний үлдэгдлийн 253,1 сая төгрөгийг тайлант оны үр дүнтэй тулгах

**<u>Эрсдэлүүд</u>**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангах

**<u>ҮАГ-ын зөвлөмж</u>**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангах
Санхүүгийн тайланг залруулах

**<u>Хэрэгжих хугацаа :</u>**

2018 оны 06 дугаар сарын 25 –ны дотор санхүүгийн програм хангамжийн тохируулгыг хийх

**<u>Төсвийн захирагчийн хариу</u>**

Аудитаар илэрсэн энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг зөвшөөрсөн болно..

2018 оны 3 дугаар сарын 25

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

| **3.3 ТАЙЛАНТ ОНЫ ҮР ДҮНГИЙН ТАЛААР** | **Тэргүүлэх ач холбогдол №3** |
|---|---|

**ҮАГ-ын ажиглалт**

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн тайлант оны үйл ажиллагааны нийт үр дүнг Цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайлангаархи тайлант үеийн үр дүнтгээс 5,7 сая төгрөгийн зөрүүтэй

**Эрсдэлүүд**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 үнэн зөв байх батламж мэдэглийг хангах

**ҮАГ-ын зөвлөмж**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангах

**Хэрэгжих хугацаа :**

2018 оны 06 дугаар сарын 25 –ны дотор санхүүгийн програм хангамжийн тохируулгыг хийх

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг зөвшөөрсөн болно..

2018 оны 3 дугаар сарын 25

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**МАЛ ХАМГААЛАХ САН**

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

СТ-1А

12/31/2017

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---:|---:|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 20,994,747,528.75 | 63,197,007,975.73 |
| 31 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨН | 301,817,771.08 | 18,889,105,307.00 |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | (0.00) | (0.00) |
| 31120 | Гадаад валют | (0.00) | (0.00) |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 301,817,771.08 | 18,889,105,307.00 |
| 3121 | Төгрөг | 301,817,771.08 | 18,889,105,307.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 0.00 | 0.00 |
| 31212 | Монгол банкин дахь харилцах | 301,817,771.08 | 19,807,690.00 |
| 31214 | Бусад төсөл нөөцийн харилцах | (0.00) | 18,869,297,617.00 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | - | 0.00 |
| 33 | АВЛАГА | 13,348,244,324.81 | 33,854,033,590.87 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 21,186,309,883.00 |
| 33300 | Татаас санхүүжилтийн авлага | 21,356,523.49 | 410,733,991.17 |
| 335 | Бусад авлага | 23,302,802.62 | 4,766,850.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 21,600,802.62 | 3,064,850.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 1,702,000.00 | 1,702,000.00 |
| 336 | Зээлийн авлага | 13,303,584,998.70 | 12,252,222,866.70 |
| 3361 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авл | 13,303,584,998.70 | 12,252,222,866.70 |
| 33611 | Засгийн газрын байгууллага, бусад шатны | 170,217,305.40 | 143,902,505.40 |
| 33612 | Хувь хүмүүст олгосон зээл | 188,542,958.00 | 188,542,958.00 |
| 33613 | Сургалтын төрийн сангийн зээлийн авлага | 2,023,616,980.90 | 1,757,177,210.90 |
| 33614 | Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосо | 483,702,185.00 | 438,261,185.00 |
| 33615 | Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосо | 10,437,505,569.40 | 9,724,339,007.40 |
| 34 | УРЬДЧИЛГАА | - | 4,000,000.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 4,000,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 7,344,685,432.86 | 10,449,869,077.86 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 5,250,762,048.43 | 4,792,402,048.43 |
| 354 | Хангамжийн материал | 9,583,598.00 | 4,985,398.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,292,100.00 | 1,153,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,951,798.00 | 1,951,798.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 258,500.00 | 258,500.00 |
| 35440 | Түлш шатах тослох материал | 2,500,000.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3,581,200.00 | 1,621,200.00 |
| 35600 | Мал, амьтад | 2,084,339,786.43 | 5,652,481,631.43 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 227,554,730.56 | 203,056,761.20 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 227,554,730.56 | 203,056,761.20 |
| 392 | Биет хөрөнгө | 227,288,063.84 | 202,890,094.44 |
| 39201 | Барилга, байгууламж | 342,446,500.00 | 342,446,500.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (159,248,057.04) | (178,194,824.52) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 50,985,900.00 | 50,985,900.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (34,698,737.50) | (43,196,387.50) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 44,339,980.01 | 55,360,550.01 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (30,699,096.77) | (35,532,274.29) |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 33,714,575.00 | 33,714,575.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (19,886,333.06) | (22,693,944.26) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,666,666.80) | (2,000,000.00) |
| 393 | Биет бус хөрөнгө | 266,666.72 | 166,666.76 |
| 39301 | Програм хангамж | 13,555,000.00 | 13,555,000.00 |
| 39302 | Хасагдуулга | (13,288,333.28) | (13,388,333.24) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 21,222,302,259.31 | 63,400,064,736.93 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 26,162,237.92 | 40,035,792,199.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 26,162,237.92 | 40,035,792,199.00 |
| 413 | Өглөг | 26,162,237.92 | 35,792,199.00 |
| 4131 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | (0.00) | - |
| 4132 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | 40,000,000,000.00 |
| 41330 | Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг | 9,177,728.92 | 19,807,690.00 |
| 4136 | Бусад өглөг | 16,984,509.00 | 15,984,509.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 9,894,999.00 | 9,894,999.00 |
| 41362 | Хувь хүмүст төлөх өглөг | 7,089,510.00 | 6,089,510.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 21,196,140,021.39 | 23,364,272,537.93 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 21,196,140,021.39 | 23,364,272,537.93 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ | 1,514,078,031.90 | 1,514,078,031.90 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 1,514,078,031.90 | 1,514,078,031.90 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 19,682,061,989.49 | 21,850,194,506.03 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 19,682,061,989.49 | 19,682,061,989.49 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 2,168,132,516.54 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН | 21,222,302,259.31 | 63,400,064,736.93 |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**МАЛ ХАМГААЛАХ САН**

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

СТ-2А

12/31/2017

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 29,183,281,220.02 | 39,403,177,686.60 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 284,767,696.53 | 334,851,567.60 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 284,767,696.53 | 334,851,567.60 |
| 120003 | Торгуулийн орлого | 1,719,422.00 | 11,388,385.60 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 283,048,274.53 | 317,685,082.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 186,945,694.53 | 169,063,036.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 96,102,580.00 | 148,622,046.00 |
| 1200047 | Тендерийн материал худалдсаны орлого | - | 5,778,100.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 28,898,513,523.49 | 39,068,326,119.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 28,877,157,000.00 | 38,921,927,045.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 28,877,157,000.00 | 35,353,785,200.00 |
| 131004 | Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | - | 3,568,141,845.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 21,356,523.49 | 135,378,504.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж | 21,356,523.49 | 135,378,504.00 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | - | 11,020,570.00 |
| 133003 | Хөрөнгийн | - | 11,020,570.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 28,930,730,090.09 | 37,236,655,170.06 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 291,452,261.17 | 1,588,374,368.98 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 291,452,261.17 | 1,588,374,368.98 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 155,890,126.62 | 197,871,799.34 |
| 210101 | Цалин | 142,277,626.62 | 143,392,461.23 |
| 210102 | Нэмэгдэл цалин | - | 19,938,600.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,612,500.00 | 17,152,179.00 |
| 210105 | Гэрээтийн цалин | - | 17,388,559.11 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 16,908,933.96 | 21,773,099.99 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 10,764,408.27 | 13,584,016.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 1,306,042.64 | 2,201,743.38 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,490,944.64 | 1,797,298.43 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 303,828.80 | 388,093.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 3,043,709.61 | 3,801,947.64 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,500,000.00 | - |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 1,500,000.00 | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 27,227,863.77 | 40,981,809.14 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 5,843,930.00 | 5,349,010.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 10,103,500.00 | 27,862,439.00 |
| 210403 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 6,823,438.77 | 3,881,320.14 |
| 210404 | Ном, хэвлэлийн зардал | - | 210,000.00 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 4,456,995.00 | 3,679,040.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,398,000.00 | 1,485,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,398,000.00 | 1,485,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,462,600.00 | 5,584,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,462,600.00 | 5,584,900.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 25,146,826.00 | 34,271,955.00 |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 25,146,826.00 | 34,271,955.00 |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 13,079,877.00 | 21,974,766.15 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,883,623.00 | 20,769,936.15 |
| 210803 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 123,830.00 | 115,830.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 196,100.00 | 198,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэсглийн оношилгоо | 76,000.00 | 99,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 800,324.00 | 792,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 44,838,033.82 | 1,264,431,039.36 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,319,800.00 | 1,228,912,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 39,518,233.82 | 35,518,539.36 |
| 212 | ТАТААС | 28,627,446,228.92 | 35,638,688,801.08 |
| 2122 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 28,627,446,228.92 | 35,638,688,801.08 |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 28,627,446,228.92 | 35,638,688,801.08 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 11,831,600.00 | 9,592,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 11,831,600.00 | 9,592,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 11,831,600.00 | 5,992,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | - | 3,600,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 252,551,129.93 | 2,166,522,616.54 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV) | 605,885.93 | 1,610,000.00 |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | 605,885.93 | 1,610,000.00 |
| 6 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V) | 605,885.93 | 1,610,000.00 |
| 7 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 253,157,015.86 | 2,168,132,516.54 |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**МАЛ ХАМГААЛАХ САН**

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

СТ-3А

12/31/2017

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 29,557,418,413.87 | 75,791,743,053.55 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 658,904,890.38 | 260,160,326.06 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 658,904,890.38 | 260,160,326.06 |
| 120003 | Торгуулийн орлого | 1,955,130.00 | - |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 647,772,031.46 | 254,382,226.06 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 158,596,947.86 | 162,889,428.98 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 106,495,164.00 | 82,168,046.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 382,679,919.60 | 9,324,751.08 |
| 1200047 | Тендерийн материал худалдсаны орлого | - | 5,778,100.00 |
| 120009 | Бусад орлого | 9,177,728.92 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 28,898,513,523.49 | 75,531,582,727.49 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 28,877,157,000.00 | 75,353,785,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 28,877,157,000.00 | 75,353,785,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 21,356,523.49 | 177,797,527.49 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж | 21,356,523.49 | 135,378,504.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | - | 21,356,523.49 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон | | 21,062,500.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 28,932,781,285.93 | 36,445,395,859.10 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 28,932,781,285.93 | 36,445,395,859.10 |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 253,644,453.52 | 406,188,756.85 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 155,890,126.62 | 197,871,799.34 |
| 210101 | Үндсэн цалин | 142,277,626.62 | 143,392,461.23 |
| 210102 | Нэмэгдэл | - | 19,938,600.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,612,500.00 | 17,152,179.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 17,388,559.11 |
| 2102 | Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл | 16,908,933.96 | 21,773,099.99 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 10,764,408.27 | 13,584,016.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 1,306,042.64 | 2,201,743.38 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,490,944.64 | 1,797,298.43 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 303,828.79 | 388,093.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 3,043,709.62 | 3,801,947.64 |
| 2103 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 1,500,000.00 | - |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 1,500,000.00 | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 30,119,012.94 | 38,290,136.52 |

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 6,202,930.00 | 5,255,810.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,193,500.00 | 25,362,439.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,813,487.94 | 3,827,847.52 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 210,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,909,095.00 | 3,634,040.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,398,000.00 | 1,485,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,398,000.00 | 1,485,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,462,600.00 | 5,584,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,462,600.00 | 5,584,900.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 25,146,826.00 | 34,271,955.00 |
| 210701 | Дотоод албан томилолт | 25,146,826.00 | 34,271,955.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 11,899,154.00 | 25,249,366.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 10,702,900.00 | 24,044,536.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 123,830.00 | 115,830.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 196,100.00 | 198,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 76,000.00 | 99,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 800,324.00 | 792,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,319,800.00 | 81,662,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,319,800.00 | 81,662,500.00 |
| 212 | ТАТААС | 28,627,446,228.92 | 35,618,881,111.08 |
| 2122 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 28,627,446,228.92 | 35,618,881,111.08 |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 28,627,446,228.92 | 35,618,881,111.08 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 51,690,603.49 | 420,325,991.17 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 11,831,600.00 | 9,592,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 11,831,600.00 | 5,992,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | - | 3,600,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 39,859,003.49 | 410,733,991.17 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 39,859,003.49 | 410,733,991.17 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 624,637,127.94 | 39,346,347,194.45 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV) | 1,185,293,043.14 | 1,361,642,724.47 |
| 12401 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа эргэн төлөлт | 1,185,293,043.14 | |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 6,219,400.00 | - |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 6,219,400.00 | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 6,219,400.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 6,219,400.00 | - |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | 1,179,073,643.14 | 1,361,642,724.47 |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙН ХАССАН ЗЭЭЛ | 1,554,000,000.00 | 40,990,000,000.00 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 1,554,000,000.00 | 40,990,000,000.00 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | 1,554,000,000.00 | 40,990,000,000.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 249,710,771.08 | (282,010,081.08) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 52,107,000.00 | 301,817,771.08 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 301,817,771.08 | 18,889,105,307.00 |

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

**МАЛ ХАМГААЛАХ САН**

## АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

СТ-4А

12/31/2017

| КОД | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2016 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | - | 0.00 | 0.00 | 0.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C04 | Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C05 | Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C08 | 2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D01 | 2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,514,078,031.90 | 0.00 | 19,682,061,989.49 | 21,196,140,021.39 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,514,078,031.90 | 0.00 | 19,682,061,989.49 | 21,196,140,021.39 |
| D04 | Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0.00 | 0.00 | 2,168,132,516.14 | 2,168,132,516.14 |
| D09 | 2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,514,078,031.90 | 0.00 | 21,850,194,506.03 | 23,364,272,537.93 |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**МАЛ ХАМГААЛАХ САН**

## АУДИТ ХИЙГДСЭН  ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

12/31/2017

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
|---|---|---:|---:|---:|---:|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 301,817,771.08 | (301,817,771.08) | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 77,567,137,700.00 | 76,916,720,503.93 | 650,417,196.07 | 99.16 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 35,658,137,700.00 | 35,926,720,503.93 | (268,582,803.93) | 100.75 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 298,352,500.00 | 298,247,392.82 | 105,107.18 | 99.96 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 197,937,600.00 | 197,871,799.34 | 65,800.66 | 99.97 |
| 210101 | Үндсэн цалин | 136,015,100.00 | 143,392,461.23 | (7,377,361.23) | 105.42 |
| 210102 | Нэмэгдэл | 19,938,600.00 | 19,938,600.00 | - | 100.00 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 13,471,900.00 | 17,152,179.00 | (3,680,279.00) | 127.32 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 28,512,000.00 | 17,388,559.11 | 11,123,440.89 | 60.99 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 21,773,100.00 | 21,773,099.99 | 0.01 | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,855,600.00 | 13,584,016.75 | 271,583.25 | 98.04 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,979,400.00 | 2,201,743.38 | (222,343.38) | 111.23 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 1,583,500.00 | 1,797,298.43 | (213,798.43) | 113.50 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 395,900.00 | 388,093.79 | 7,806.21 | 98.03 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,958,700.00 | 3,801,947.64 | 156,752.36 | 96.04 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 18,831,800.00 | 18,831,197.52 | 602.48 | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,421,100.00 | 4,485,810.00 | (64,710.00) | 101.46 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 6,917,100.00 | 6,883,500.00 | 33,600.00 | 99.51 |
| 210403 | Шуудан  холбоо, интернэтийн төлбөр | 3,858,600.00 | 3,827,847.52 | 30,752.48 | 99.20 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 3,635,000.00 | 3,634,040.00 | 960.00 | 99.97 |
| 2105 | Нормативт зардал | 1,485,000.00 | 1,485,000.00 | - | 100.00 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 1,485,000.00 | 1,485,000.00 | - | 100.00 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 5,584,900.00 | 5,584,900.00 | - | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,584,900.00 | 5,584,900.00 | - | 100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 27,457,900.00 | 27,452,030.00 | 5,870.00 | 99.98 |
| 210702 | Дотоод албан томилолт | 27,457,900.00 | 27,452,030.00 | 5,870.00 | 99.98 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 25,282,200.00 | 25,249,366.00 | 32,834.00 | 99.87 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 24,044,700.00 | 24,044,536.00 | 164.00 | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 148,500.00 | 115,830.00 | 32,670.00 | 78.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 198,000.00 | 198,000.00 | - | 100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 99,000.00 | 99,000.00 | - | 100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 792,000.00 | 792,000.00 | - | 100.00 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | - | - | |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | - | - | |
| 212 | ТАТААС | 35,350,185,200.00 | 35,618,881,111.08 | (268,695,911.08) | 100.76 |
| 2122 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 35,350,185,200.00 | 35,618,881,111.08 | (268,695,911.08) | 100.76 |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 35,350,185,200.00 | 35,618,881,111.08 | (268,695,911.08) | 100.76 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 9,600,000.00 | 9,592,000.00 | 8,000.00 | 99.92 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 9,600,000.00 | 9,592,000.00 | 8,000.00 | 99.92 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 6,000,000.00 | 5,992,000.00 | 8,000.00 | 99.87 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 3,600,000.00 | 3,600,000.00 | - | 100.00 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 41,909,000,000.00 | 40,990,000,000.00 | 919,000,000.00 | 97.81 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 41,909,000,000.00 | 40,990,000,000.00 | 919,000,000.00 | 97.81 |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 77,567,137,700.00 | 76,919,980,750.53 | 647,156,949.47 | 99.17 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 75,353,785,200.00 | 75,353,785,200.00 | - | 100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 75,353,785,200.00 | 75,353,785,200.00 | - | 100.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 2,213,352,500.00 | 1,545,133,050.53 | 668,219,449.47 | 69.81 |
| 1200041 | Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,213,352,500.00 | 1,530,030,199.45 | 683,322,300.55 | 69.13 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 5,778,100.00 | (5,778,100.00) | - |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | - | 9,324,751.08 | (9,324,751.08) | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 21,062,500.00 | (21,062,500.00) | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээ | | 21,062,500.00 | (21,062,500.00) | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 301,817,771.08 | (301,817,771.08) | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 18,889,105,307.00 | (18,889,105,307.00) | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 12.00 | 12.00 | | |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10.00 | 10.00 | | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 1.00 | 1.00 | | |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ